

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага	MNS 5537 : 2016
Road side station along the road network – Classification and General requirements	MNS 5537 : 2005-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 28 –ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь автотээврийн хэрэгслийн жолоочийн ажил амралтын дэглэмийг хангах, зорчигчдын тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийн техникийн хэвийн үйл ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээний цогцолборыг хөгжүүлэх, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборыг төлөвлөх, барьж байгуулах үйл ажиллагаанд хамаарна.

2.2. Автозамын дагуух үйлчилгээний цогцолборт хамрагдах үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хяналт тавих эрх бүхий байгууллага, ажилтан мөрдөж ажиллана.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас ашиглана. Үүнд:

3.1. БНБД 32-01-07 “Авто зам төсөллөх”

3.2. БНБД31-03-03 “Олон нийт иргэний барилга төсөллөх”

3.3. БНБД21-01-02 ”Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал”;

3.4. MNS 5025:2010 “Авто үйлчилгээ – ангилал, ерөнхий шаардлага”;

3.5. MNS 5342:2003 “Автомашинны зогсоол, ангилал, ерөнхий шаардлага”;

3.6. MNS 5346:2003 ”Автомашинны угаалгын үйлчилгээ, ангилал, ерөнхий шаардлага”;

3.7. MNS 4588:2008 “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага”;

3.8. MNS 5927:2008 “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага”;

3.9. MNS 4934:2002 ”Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага”;

3.10. MNS 5231:2003” Жуулчны автотээврийн үйлчилгээ, ерөнхий шаардлага”;

3.11. MNS 5409:2004 “Аялал жуулчлалын үндсэн нэр томъёо”;

3.12. MNS 4946:2005 “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага”;

3.13. MNS 900:2005 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага”;

3.14. MNS 5021:2007 “Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага”;

- 3.15.** MNS 6056:2009 “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”;
- 3.16.** MNS 5682:2006 “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага”
- 3.17.** MNS 4244:94 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”;
- 3.18.** MNS 4244:94 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”;
- 3.19.** MNS 5566:2005 “Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”;
- 3.20.** MNS 4244:94 “Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага”;
- 3.21.** MNS 900:92 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага”;
- 3.22.** MNS 4628:2013 “Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага”.
- 3.23.** MNS 5163:2002 “Халуун усны үйлчилгээ, ерөнхий шаардлага”
- 3.24.** MNS 5667:2006 “Бохир ус. Лагийн чийглэг ба үнслэгийг тодорхойлох арга”
- 3.25.** MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”
- 3.26.** MNS 4596:2014 “Автозамын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”
- 3.27.** ГОСТР 52766-2007 Дороги автомобильные общего пользования. Элементы обустройства. Общие требования
- 3.28.** СТ РК 2476-2014 Дороги автомобильные общего пользования требования к объектам дорожного сервиса и их услугам. Национальный стандарт республики Казахстан
- 3.29.** БНСУ-ын Үндэсний стандарт–Замын аюулгүй байдал, туслах байгууламж ба орчин.

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1.

Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор

авто замын дагуу байрлах, жолооч болон зорчигчдод аялалын явцад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийг техникийн засвар үйлчилгээ, шатах тослох материалаар хангах зэрэг үйлчилгээг нэг дор үзүүлэх байгууламж. /цаашид “үйлчилгээний цогцолбор” гэх/

4.2.

Түр зогсох талбай

тээврийн хэрэгсэл түр хугацаанд зогсоход зориулсан талбай.

4.3.

Зорчигч урсгал

авто замын сүлжээний тодорхой хэсэгт нэг чиглэлд, нэгж хугацаанд тээвэрлэсэн буюу тээвэрлэж болох зорчигчийн тоо.

4.4.

Хөдөлгөөний эрчим

нэгж хугацаанд тухайн замаар зорчин өнгөрөх тээврийн хэрэгслийн тоо.

4.5.**Нийтийн үйлчилгээний байр**

жолооч, зорчигчдод нэг цэгт үйлчилгээ үзүүлэх байгууламж.

5. Үйлчилгээний цогцолборт тавигдах нийтлэг шаардлага

5.1. Үйлчилгээний цогцолборыг тухайн авто замын ангилал, хөдөлгөөний эрчим, цаг уур, орчны нөхцөл байдал, жолоочийн ажил амралтын дэглэм зэргийг харгалзан “Авто зам төсөллөх” БНБД 32-01-тэй нийцүүлэн, тухайн байгууламжийг төсөллөх норм, түүнчлэн тэдгээрийн байршлын ерөнхий бүдүүвч, зураг төслийн дагуу байгуулна.

5.2. Үйлчилгээний цогцолборын байршлыг авто замын сүлжээний эхлэлийн цэгээс тооцох бөгөөд цогцолбор хоорондын зайг 250 км-ээс ихгүй, ашиглалтын хугацааг 15 жилээс багагүй байхаар төлөвлөнө.

5.3. Үйлчилгээний цогцолборыг 1000 м-ээс багагүй зайд огцом эргэлт, эгц уруу, зэрэг замын үзэгдэлтийг хязгаарлаагүй, харагдах байдал сайтай газарт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан орц, гарцтайгаар зөвшөөрөгдсөн зай, талбайд байгуулна.

5.4. Үйлчилгээний цогцолборын байгууламжууд нь хүрээлэн буй орчин, хүн амд сөрөг нөлөөгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.

5.5. Үйлчилгээний цогцолбор нь хоногийн 24 цагийн турш үйлчилгээ үзүүлнэ.

5.6. Цогцолборын байгууламжууд нь галын аюулгүй байдлын холбогдох стандартын шаардлагын дагуу галын аюулгүйн таних тэмдэг бүхий аваарын гарц, бүдүүвч, гал унтраах хэрэгсэлтэй байхаас гадна зам талбайн гэрэлтүүлэг, дотоод хяналтын системийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

5.7. Үйлчилгээний цогцолбор нь “Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор” гэсэн нэгдсэн хаягтай, дагалдах байгууламжууд нь тус тусын үйлчилгээний нэр хаягтай байх ба тэдгээр нь өдөр, шөнийн аль ч цагт тод харагдахуйц байна.

5.8. Үйлчилгээний цогцолборын зохион байгуулалтын бүдүүвч схем, үйлчилгээний байгууламж, цэгүүдийг томъёолсон тэмдэглэл, хаягийг Монгол хэл дээр бичиж байрлуулсан байна.

5.9. Үйлчилгээний цогцолборын байршлыг мэдээлэх тэмдгийг “Автозамын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын дагуу байрлуулна.

5.10. Цахилгааны болон ундны цэвэр усны нөөц эх үүсвэртэй байх ба цахилгаан ба усан хангамжийг цаашид нэмэгдүүлэх боломжийг тооцсон байх.

5.11. Үйлчилгээний цогцолбор нь “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам.

Техникийн шаардлага” MNS 5682:2006 стандартуудын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

5.12. Үйлчилгээний цогцолбор нь интернет болон гар утасны сүлжээнд холбогдсон үйлчилгээний мэдээллийг /утасаар, цахим хэлбэрээр, хэвлэмэл байдлаар/ авах боломжтой, шаардлагатай үед шуудан холбоогоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх.

5.13. Тээврийн хэрэгслийн үйлчилгээний бүс нь аль болохоор авто замд ойр, зорчин явагчдад зориулсан үйлчилгээний бүсийг авто замаас 50 метрээс багагүй зайд байрласан байхаар төлөвлөх.

5.14. Үйлчилгээний цогцолборын авто зогсоолын багтаамж нь үйлчилгээний объектуудын багтаамж болон ажлын горим, зорчигчдыг үйлчлэх хэлбэрт тохирсон Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага MNS 5342:2003 шаардлагад нийцсэн байх.

5.15. Авто зогсоолын талбайг төлөвлөхдөө тухайн авто замын хөдөлгөөний эрчмээс хамааруулан оргил ачааллын үеийн тээврийн хэрэгслийн тоонд үндэслэн тооцно.

5.16. Авто зогсоолыг ачааны автомашин, суудлын автомашин, хүнд даацын тээврийн хэрэгсэл, автобус зогсох байдлаар төрөлжүүлэн зохион байгуулна.

6. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборын ангилал

6.1. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборыг улс, хот хооронд зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмээс хамааруулан дараах ангиллын байна. Үүнд

1-р хүснэгт - Авто замын дагуух үйлчилгээний цогцолборын ангилал

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний цогцолборын ангилал		
	A	B	C
Байршил	Хурдны зам	I, II, III зэргийн зам	IV, V зэргийн болон сайжруулсан болон ердийн хөрсөн зам
Хөдөлгөөний эрчим, хоногоор	10000-аас дээш	5000-10000 хүртэл	5000 хүртэл
Хоорондын зай	250 км-ээс ихгүй зайд		
Нийт талбайн хамгийн бага хэмжээ	1000 м ²	600 м ²	300 м ²
Нийтийн үйлчилгээний байртай эсэх	шаардлагатай		байж болно
Нийтийн бие засах газар	Нийтийн үйлчилгээний байранд эрүүл ахуйн шаардлага хангасан зохих хэрэгслээр тоноглогдсон эрэгтэй эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байна. /өрөөнд 10-аас доошгүй суултуур суурилуулсан байна./		Шаардлага хангасан зайд тусдаа байна

Дагалдах байгууламж			
Зорчигч үйлчилгээний чиглэлээр			
Хоолны газар	- Түргэн үйлчилгээний ресторан - Кафе		Гуанз
Зочид буудлын үйлчилгээ	30-аас багагүй ортой	10-аас багагүй ортой	шаардлагагүй
Худалдаа үйлчилгээ	Супермаркет Дэлгүүр	Дэлгүүр Мини маркет	Мухлаг
Техникийн үйлчилгээний чиглэлээр			
Авто үйлчилгээний газар	В2. С3	В3. С3	С3
Шатахуун түгээх станц	ШТС	ШТС	Зөөврийн
Авто зогсоол	Тээврийн хэрэгслийн ангиллын дагуу хатуу хучилттай дулаан болон ил зогсоолтой байна. /зогсоолын нийт талбайн хэмжээ нь үйлчилгээний цогцолборын талбайн 60 хувиас багагүй байх/		Ил зогсоол
Автомашин угаалга	Механикжсан, Хагас механикжсан	Хагас механикжсан, Гар аргаар	шаардлагагүй
Аюулгүй байдал, хяналтын чиглэлээр			
Гэрэлтүүлэг	шаардлагатай	шаардлагатай	байж болно
Орц, гарц	шаардлагатай	шаардлагатай	шаардлагатай
Зогсоол, замын тэмдэглэгээ	шаардлагатай	шаардлагатай	шаардлагатай
Хурд сааруулагч	шаардлагатай	шаардлагатай	шаардлагатай
Хяналтын камер	шаардлагатай	шаардлагатай	байж болно

6.2. Авто замын зэрэглэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, зорчигч урсгалын хэмжээнээс хамааран 2-р хүснэгтэд заасан үйлчилгээг иж бүрэн болон хэсэгчилсэн, түр болон байнгын байдлаар үзүүлнэ.

- 6.3.** Үйлчилгээний цогцолборыг зориулалтаар нь гурван бүсэд хуваана. Үүнд:
- Тээврийн хэрэгслийн үйлчилгээнд зориулсан (Шатах тослох материал борлуулах газар, техникийн үйлчилгээний станц, автозогсоол /дулаан болон ил зогсоол/)
 - Зорчигчид болон жолооч нарт зориулсан (амрах болон хүлээх талбай, хооллох газар, худалдааны газар, зочид буудал)
 - Эрүүл ахуйн бүс (нийтийн бие засах газар, хогийн цэг)

6.4. Үйлчилгээний цогцолборын үйлчилгээг үндсэн болон нэмэлт үйлчилгээ гэж ангилна.

6.5. Үндсэн үйлчилгээ нь тухайн цогцолборт зайлшгүй байх шаардлагатай үйлчилгээ бөгөөд нэмэлт үйлчилгээ нь эрэлт хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний төрөл, хугацааг сонгох үйлчилгээ хамаарна.

2-р хүснэгт - Авто замын дагуух үйлчилгээний цогцолборт үзүүлэх үйлчилгээ

Үйлчилгээний төрөл	А	В	С
Үндсэн үйлчилгээ	Зорчигч болон жолоочид зориулсан		
	Нийтийн үйлчилгээний байранд: - Хүлээх танхим - Нийтийн бие засах газар - Эмнэлгийн анхны тусламж - Ундны ус - Холбоо, мэдээллийн үйлчилгээ - Эх нялхсын өрөө Дагалдах байгууламжид: - Хоолны газар - Зочид буудал		- Нийтийн бие засах газар - Ундны ус - Жолоочийн амралтын өрөө
	Тээврийн хэрэгсэлд зориулсан		
	Дагалдах байгууламжид: - шатах тослох материалын үйлчилгээ; - авто зогсоолын үйлчилгээ /дулаан болон ил зогсоол/ - авто засварын үйлчилгээ;		- авто зогсоолын үйлчилгээ - авто засварын үйлчилгээ;
Нэмэлт үйлчилгээ	Зорчигч болон жолоочид зориулсан		
	Нийтийн үйлчилгээний байранд үзүүлж болох үйлчилгээ: ▪ Тээш хадгалах ▪ Хувцас угаалга ▪ Халуун ус ▪ Тамхи татах цэг ▪ Даатгал ▪ АТМ гэх мэт		
	Тээврийн хэрэгсэлд зориулсан		
	- автомашин угаалга - авто сэлбэгийн худалдаа - техникийн түргэн тусламжийн үйлчилгээ гэх мэт		

7. Үйлчилгээний цогцолборын үйлчилгээнд тавигдах шаардлага

7.1. Авто замын дагуух үйлчилгээний цогцолборын нийтийн үйлчилгээний байр, дагалдах байгууламжид үзүүлэх үйлчилгээ нь холбогдох стандартын шаардлага хангасан байна.

7.2. Үйлчилгээний цогцолборын ажилтнууд нь тухайн үйлчилгээний чиглэлийн мэргэжлийн болон мэргэшсэн ажилтан байна.

7.3. Нийтийн үйлчилгээний байрны үйлчилгээнд тавигдах нэмэлт шаардлага

7.3.1. Нийтийн үйлчилгээний байр нь жолооч, зорчигчдод нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх үндсэн байгууламж бөгөөд үйлчлүүлэгчдэд тав тухтай амрах, үйлчлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.3.2. Нийтийн үйлчилгээний байранд энэхүү стандартын 6.5-д заасан үйлчилгээг үзүүлнэ.

7.3.3. Нийтийн үйлчилгээний байрны хүлээлгийн танхим нь агаарын хэвийн солилцоог хангасан, зорчигчийн сууж амрах сандал, зурагт, сонин хэвлэл, тухайн объектын болон замын мэдээллийг авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн, жолооч, зорчин явагчдад цаг агаар, замын нөхцөл байдал, Монгол Улсын авто замын сүлжээ, улс хот хоорондын замналын талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн байна.

7.3.4. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.3.5. Шуудан холбоо, утас, интернет, факсаар үйлчлэх бололцоотой, хүлээх танхим нь утасгүй интернетэд холбогдох боломжтой байна.

7.3.6. Хүлээлгийн танхимд ундны усаар үйлчлэх үйлчилгээ байх бөгөөд ундны ус нь MNS 900:2005 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага” хангасан байна.

7.3.7. С ангилалын үйлчилгээний цогцолбор нь жолоочийн ажил амралтын дэглэмийн дагуу жолоочийн амралтын өрөөтэй байна. Амрах байрны талбайг нэг жолоочид 5 м²-аас багагүй байхаар тооцно.

7.3.8. Эх нялхсын өрөө нь бусад үйлчилгээний цэгүүдээс тусдаа хүүхэд амрах, хооллох, өлгий, хувцас, живхийг солих боломжийг бүрдүүлсэн байхаар зохион байгуулна.

7.3.9. Нийтийн бие засах газар нь нийтийн үйлчилгээний байранд болон тусдаа байж болно.

7.3.10. Нийтийн хэрэгцээнд зориулсан ариун цэврийн өрөөний талбайг 1 цагт үйлчлэх хамгийн их зорчигчийн тооноос хамааруулан тооцох бөгөөд “Автотээврийн үйлчилгээ. Зорчигч тээврийн автобуудал. Ерөнхий шаардлага” MNS 6200:2011 стандартын 6.1.8 –д заасан аргачлалын дагуу тооцож болно.

7.3.11. Нийтийн бие засах газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай өрөөтэй, зохих хэрэгслээр тоноглогдсон байна.

7.4. Нийтийн үйлчилгээний байран дахь нэмэлт үйлчилгээнд тавигдах шаардлага

7.4.1. Нийтийн үйлчилгээний байранд энэхүү стандартын 6.5 дахь хэсэгт заасан нэмэлт үйлчилгээг сонгон үзүүлж болно.

7.4.2. Хувцас угаалгын газар нь хувцсыг хүлээн авч, угаах, индүүдэх үйлчилгээг үзүүлэх, эсвэл бүрэн автомат угаалгын машин ашиглаж, үйлчлүүлэгч өөрөө хувцсаа угаах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.4.3. Халуун усны газар нь үйлчлүүлэгчийг түргэн хугацаанд усанд орох боломжийг бүрдүүлсэн байх ба “Халуун усны үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS 5163:2002 стандартад нийцсэн байна.

7.4.4. Тээш хадгалах үйлчилгээ нь зорчигчийн тээшийг хүлээн авах, хадгалах, олгох тусгай өрөө, эсвэл автомат хайрцагтай байна.

7.4.5. Тээш хадгалах өрөө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд.

7.4.5.1. Тээшийг хадгалах тавиуртай, өрөөний хэмийг автоматаар болон механик аргаар тохируулах боломжтой байна.

7.4.5.2. Тээшний тавиурын доод тавцан нь шалнаас дээш 70 см-аас илүүгүй өндөрт байрласан байх тавиурын давхар хооронд 70 см-ээс багагүй зайтай, 3-аас дээшгүй давхар байх ба тавиур хоорондын сул зай нь 1,2 м-ээс доошгүй өргөнтэй байна.

7.4.6. Тамхи татах цэг нь тусгай өрөөтэй байх ба өрөө нь агааржуулалтын системтэй байна. Энэхүү өрөөнөөс бусад газарт тамхи татахыг хориглоно.

7.5. Хоолны газарт тавигдах нэмэлт шаардлага

7.5.1. Хоолны газар нь хэрэглэгчийн таашаалд нийцсэн иж бүрдэлтэй, үйлчилгээний чанарын зэрэглэлийн түвшин, эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

7.5.2. Үйлчилгээний цогцолборын байрлал, хүчин чадал, зорчигч урсгалаас хамааран түргэн хоолны ресторан, кафе, цайны газар зэрэг үйлчилгээг үзүүлж болно.

7.6. Худалдааны газарт тавигдах нэмэлт шаардлага

7.6.1. Худалдааны газар нь “Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS 5021:2007 стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.

7.6.2. Худалдааны газар нь үйлчлүүлэгчдэд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаатай, бараа бүтээгдэхүүнээр үйлчлэхийн зэрэгцээ нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн гар урлал, бэлэг дурсгал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг борлуулж болно.

7.7. Авто зогсоолд тавигдах нэмэлт шаардлага

7.7.1. “Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага” MNS 5342 : 2003 стандартын шаардлагад нийцсэн байна.

7.7.2. А,В ангилалын үйлчилгээний цогцолборт нийт авто зогсоолын талбайн 10 хувиас багагүй талбай нь халаалттай битүү зогсоол байна.

7.7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоолыг нийтийн үйлчилгээний байранд хамгийн ойр байхаар зохион байгуулна.

7.8. Авто засвар үйлчилгээний газарт тавигдах нэмэлт шаардлага

7.8.1. Авто засвар, үйлчилгээний газар нь “Авто үйлчилгээ, ангилал, ерөнхий шаардлага” MNS 5025 : 2001 стандартын шаардлагад нийцсэн байна.

7.8.2. А ангилалын үйлчилгээний цогцолборын авто засвар үйлчилгээний газар нь суурин үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ техникийн явуулын үйлчилгээг үзүүлнэ.

7.9. Шатахуун түгээх станцын үйлчилгээнд тавигдах нэмэлт шаардлага

7.9.1. Шатахуун түгээх станц нь “Шатахуун түгээх станц барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” MNS 4628 : 98 стандартын шаардлагад нийцсэн байна.

7.9.2. Үйлчилгээний цогцолборын хүчин чадлаас хамааруулан суурин болон зөөврийн, явуулын станцтай байж болно.

8. Үйлчилгээний цогцолборын барилга байгууламжид тавигдах нэмэлт шаардлага

8.1. Үйлчилгээний цогцолборын барилга байгууламж нь барилгын зураг төсөл, норматив техникийн баримт бичиг, стандартын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд нэгдсэн нэг загвар, өнгөтэй байна.

8.2. Барилгын хэмжээг хүчин чадлаас хамааруулан барилгын норм, дүрэмд нийцүүлэн тогтооно.

8.3. Шатахуун түгээх станц (ШТС), техник үйлчилгээний төвийн барилгыг галын аюулгүй байдлын шаардлага хангасан зайд хамт байгуулж болно.

8.4. ШТС-аас үйлчилгээний цогцолборын барилгын хана хүртэлх зай нь нэг буюу хоёр цэнэглэх колонктой бол 25 м-ээс, гурав ба түүнээс олон цэнэглэх колонктой бол 50 м-ээс багагүй зайд байгуулах.

8.5. Авто замын зурвас газарт ШТС-ыг байгуулах хамгийн бага зай нь замын хөвөөний ирмэгээс I ангиллын замд 25 м, бусад ангиллын замд 15 м-ээс багагүй байх. Энэ зайг шатахуун олгох түгээгүүр буюу газар доорхи шатахууны агуулахын захаас хэмжиж тодорхойлох.

8.6. ШТС-г зорчигч тээврийн хэрэгслийн зогсоол, эргэх талбай, явган зорчигчийн гарцнаас 25 м-ээс багагүй зайд байгуулна.

- 8.7.** ШТС-г тусгай талбайд байгуулах бөгөөд орох, гарах гарцыг тусад нь барина.
- 8.8.** 1-2 автомашин угаах байртай угаалгын газрыг нийтийн зориулалттай барилгаас 25 м-ээс багагүй зайд байгуулна.
- 8.9.** Үйлчилгээний цогцолборын гарц нь дараах шаардлагад нийцсэн байна.
- 8.9.1.** Нэг, хоёр дугаар зэрэглэлийн үйлчилгээний цогцолборын авто замтай нийлэх хэсэгт орох, гарах гарц тусдаа байх бөгөөд гурав дугаар зэрэглэлийн үйлчилгээний цогцолборын орох, гарах гарц хамт байж болно.
- 8.9.2.** Үйлчилгээний цогцолборын орц, гарц нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйн тулд хурд хасах, хурд авах зурвастай байх ба зурвасын эхлэл, төгсгөлийн хоорондох зай 50 м-ээс багагүй байх.
- 8.9.3.** Үйлчилгээний цогцолборын талбайн налуу болон түүнрүү орох замын дагуу налуу замаас эсрэг тал руу чиглэсэн байх ба эргэлтийн радиусын хязгаар 20%, талбай руу орох зам нь хатуу хучилттай байх.

9. Хөдөлгөөний аюулгүй байдалд тавигдах шаардлага

- 9.1.** Хөдөлгөөний хэтийн эрчим нь хоногт 7000-аас дээш тээврийн хэрэгсэл байх, тусгаарлах зурвас бүхий замд, үйлчилгээний цогцолборыг замын 2 талд, хоорондоо 150-200 м зайтай байхаар байгуулна.
- 9.2.** Цогцолборыг нэг болон өөр өөр түвшинд огтлолцож байгаа уулзвараас 400-500 м зайд, замын нэг талд байгуулах ба тухайн тохиолдолд эсрэг урсгалын тээврийн хэрэгсэл ижил болон ижил бус түвшингийн уулзварын орц, гарцыг ашиглаж болно.
- 9.3.** Хөдөлгөөний хэтийн эрчим хоногт 7000-аас бага байх хэсэгт цогцолборыг замын нэг талд байгуулах ба тухайн тохиолдолд эсрэг чиглэлийн тээврийн хэрэгсэл үйлчилгээний цогцолбор руу орох, цогцолбороос авто замруу орох боломжийг хангасан эргэлт гаргах, эсвэл замын нөгөө талд автомашины зогсоолыг 150 м-ээс багагүй зайтай байгуулан, явган зорчигчдод зориулсан гарц буюу гарам хийх.
- 9.4.** Үйлчилгээний цогцолборыг авто замын 4⁰⁰/о-аас илүү налуутай, 1000 м-ээс бага эргэлтийн радиустай муруй, дэвсгэр зураг дээрх муруйн дотор талд 2,0 м-ээс өндөр далантай болон хонхор хэсэгт тус тус байгуулахыг хориглоно.
- 9.5.** Гарц, орцын авто замтай холбогдох эргэлтийн радиусын хамгийн бага хэмжээ нь I, II ангиллын замд 25 м, III ангиллын замд 20 м, IV ангиллын замд 15 м-ээс, нэг эгнээтэй эсрэг урсгалтай замын зорчих хэсгийн өргөн 5,0 м-ээс (бетон хашлагатай бол 6,0 м), хөвөөний өргөн 1,5 м-ээс, хоёр эгнээтэй эсрэг урсгалын хөдөлгөөнтэй замын зорчих хэсгийн өргөн 7,0 м-ээс, хөвөөний өргөн 1,5 м-ээс тус тус багагүй байх.
- 9.6.** Гол замтай нийлэх хэсэгт үзэгдэх орчин хангагдсан байх.

10. Түр зогсох талбайд тавигдах шаардлага

10.1. Түр зогсох талбайг I, II ангиллын замд 15 км-ээс 20 км, III ангиллын замд 25 км-ээс 30 км, IV ангиллын замд 45 км-ээс 55 км тутамд байгуулна.

10.2. Талбайн багтаамжийг I ангиллын замд 20-оос 50 автомашин, II ба III ангиллын замд 10-аас 15 автомашин, IV ангиллын замд 5-аас 10 автомашин байхаар тооцох ба I ангиллын замд амрах талбайг хоёр талд хийвэл багтаамжийг 2 дахин багасгаж болно.

10.3. Түр зогсох талбайд байрлах тээврийн хэрэгслийн эзлэх талбайн хэмжээ, эргэлтийн радиусыг 3-р хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

3-р хүснэгт -Түр зогсох талбайд тээврийн хэрэгслийн эзлэх талбайн хэмжээ, эргэлтийн радиус

Тээврийн хэрэгслийн төрөл	Эзлэх талбайн хэмжээ, м	Эргэлтийн радиус, м
Суудлын автомашин	2,5 х 5,4	6,3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний автомашин	4,8 х 5,4	6,3
Ачааны автомашин		
Бага багтаамжийн	3,5 х 6,4	7,1
Дунд	3,5 х 6,8	9,0
Их	3,5 х 12,5	12,0
Хүнд даацын ачааны автомашин		
Хагас чиргүүл	3,5 х 19	12,5
Автоугсраа, 25 м урттай	3,5 х 26	12,5
Автоугсраа, 36,2 м урттай	3,5 х 38	15,0
Автоугсраа, 53,4 м урттай	3,5 х 55	15,0

10.4. Тээврийн хэрэгсэл хоорондын зай нь Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342 : 2007 стандартын шаардлагад нийцсэн байна.

10.5. Түр зогсох талбайг суурин газраас 1 км-ээс багагүй зайд байгуулна.

10.6. Түр зогсох талбай нь орц гарц бүхий тээврийн хэрэгсэл зогсох талбай, амрах бүс, эрүүл ахуйн бүсээс бүрдэнэ. Эрүүл ахуйн бүс нь бие засах газар, хогийн сав зэргээс бүрдэнэ. Нэмэлтээр техникийн үзлэгийн суваг бүхий үйлчилгээний бүс, хооллох ба худалдаа үйлчилгээний цэгтэй байж болно.

10.7. Хоолны болон худалдааны цэгийг зорчих хэсгээс аль болох хол зайд, түр зогсох талбайн гадна байгуулна.

10.8. Тээврийн хэрэгслийн түр зогсох талбайг хооллох ба худалдааны цэг, ундны усны эх үүсвэр (булаг, шанд)-ийн орчимд, тээврийн хэрэгсэл байнга зогсдог газруудад байгуулна. I-ээс III ангиллын замд, түүнийг замын зурвасны гадна талд байгуулна.


11. Хүрээлэн буй орчны тохижилт, ногоон байгууламжид тавигдах шаардлага

- 11.1.** Хүрээлэн буй орчин түүний хөрс, ус, ногоон бүсийг хамгаалах, бохирдуулахгүй байх, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох;
- 11.2.** Үйлчилгээний цогцолборыг замаас 6 м-ээс 20 м өргөн ногоон байгууламжаар тусгаарлах. Тээврийн хэрэгслийн зогсоол нь зорчих хэсгийн ирмэгээс 2,7 м-ээс багагүй зайтай байх;
- 11.3.** Хог хаягдал, бохирыг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр “Бохир ус. Лагийн чийглэг ба үнслэгийг тодорхойлох арга” MNS 5667 : 2006 болон “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943 : 2015 үндэсний стандартуудын дагуу төлөвлөх.
- 11.4.** Бохир усны цооног, нийтийн бие засах газар (тусдаа байгуулах тохиолдолд), хогийн цэгийг нийтийн үйлчилгээний байгууламжаас 25 м-ээс багагүй зайд зохилох салхины чиглэлийн дор байгуулах;
- 11.5.** Орчны болон талбайн гэрэлтүүлэгтэй байх;
- 11.6.** Шатахуун, автомашины хаягдал тос, бохирыг ил задгай асгахыг хориглоно.

ТӨГСӨВ.

А.Хавсралт
(мэдээллийн)


Авто замын дагуух “А” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схемийн загвар жишээ



А.1-р зураг - Авто замын дагуух “А” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схем зураг

В.Хавсралт
(мэдээллийн)


Авто замын дагуух “В” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схемийн загвар жишээ



В.1-р зураг - Авто замын дагуух “В” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схем зураг

**С.Хавсралт
(мэдээллийн)**


Авто замын дагуух “С” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схемийн загвар жишээ



С.1-р зураг - Авто замын дагуух “С” ангиллын үйлчилгээний цогцолборын ерөнхий схем зураг

**D.Хавсралт
(мэдээллийн)**

Түр зогсох зогсоолын ерөнхий схемийн загвар жишээ



D.1-р зураг - Түр зогсох зогсоолын ерөнхий схем зураг